



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 31 өдөр

Дугаар 9/393

Арвайхээр

2020-2022 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн  
хаах иргэдийн “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл  
сургалт”-ыг зохион байгуулж явуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 30.3, Засгийн газрын 2019 оны “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 336 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоо, сургалтад шаардагдах төсөв батлах тухай” 2020 оны 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 2020-2022 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаалгахаар сумдаас ирүүлсэн саналын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл”-шатны сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын материаллаг баазыг түшиглэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.

2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийг нэгдүгээр, “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл”-шатны сургалтад шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт явуулахад шаардагдах 10.649.600 (арван сая зургаан зуун дөчин есөн мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4. “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл”-шатны сургалтад оролцох цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын үүрэг гүйцэтгүүлэх бэлэн байдал, хувийн бэлтгэлийг хангуулж, тогтоосон хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100858

Аймгийн Засаг даргын 2020 оны 03...  
дугаарсарын 31...-ны өдрийн 01/25 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ”-ЫН  
ТӨСВИЙН ТООЦОО

| №          | Зардлын нэр   | Зардлын тооцоо  |   |   |
|------------|---|---|---|---|
|            |   | Тоо   | Нэг бүрийн дүн  | Нийт дүн  |
| 1          | Хоолны зардал<br>/Цэрэг нормоор/  | 40 хүн  | 15.000 төгрөг<br>/өдөрт 4 удаа, 14<br>хоног/  | 7.980.000 төг   |
| 2          | Замын зардал  | 40 хүн  | 52000 төгрөг /4x13.000/<br>30000 төгрөг /2x15.000/<br>40000 төгрөг /2x20.000/<br>192.000 төгрөг<br>/16x12.000/<br>80000 төгрөг /8x10.000/<br>15000 төгрөг<br>12000 төгрөг<br>12000 төгрөг /2x6.000/         | 433.000 төгрөг  |
| 3          | Хичээлийн хэрэглэл<br>- бал<br>- дэвтэр<br>-принтерийн хор<br>-бичгийн цаас<br>-бусад бичиг<br>хэргийн хэрэгсэл | 40 ш<br>40 ш<br>1ком<br>2 боодол<br>-   | 600 төг<br>1000 төг<br>80.000 төг<br>20.000 төг<br>50.000 төг   | 214.000 төгрөг  |
| 4          | ШТМ, цахилгааны<br>зардал   | - ДТ<br>- АИ-92<br>-Цахилгааны<br>зардал  | 107*1680<br>144*1380<br>-   | 180.000 төгрөг<br>199.000 төгрөг<br>120.600 төгрөг<br>Нийт: 499.000<br>төгрөг |
| 5          | Бусад зардал  | - Аймгийн төвд<br>явагдах сургалтад<br>портер машин 1<br>нэгж гарч тэдгээрт<br>ШТМ ДТ -268л<br>- Масло<br>- Портер машины<br>түрээс<br>- Түлээ 40 шуудай<br>мод<br>Ундны ус<br>-Жагсаалын дарга<br>(1), тогооч (1)<br>цалин<br>- Халуун усанд | 268x1680=450.000<br>5л*10000=50.000<br>1 өдрийн<br>20.000*10<br>хоног=200.000<br>40x5000=200.000<br>/1тн-4500/-<br>14тн*4500=63.000<br>200.000*2=400.000<br>1 хүнийг 1 удаа<br>оруулахад<br>4000*40=160.000 | 1.523.000 төгрөг  |
| <b>Дүн</b> |   |   | <b>10.649.600 төгрөг</b>  |   |